



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/29

Пионер толгой

Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг
цэвэрлүүлэх ажлыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх ажлыг сумын төвд үйл ажиллагаа эрхэлж байгаа албан байгууллага, аж ахуйн нэгжүүд, оршин суугч иргэдийг орчны цэвэрлэгээнд татан оролцуулж 2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2.Хог хаягдлын цэвэрлэгээний хуваарийг 1 дүгээр хавсралтаар, цэвэрлэгээ зохион байгуулахад гарах зардлыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3.Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал цэвэрлэх ажлыг чанартай зохион байгуулж хяналт тавьж ажиллахыг Пионер толгой 5 дугаар багийн Засаг дарга Ч.Батцэцэг, Байгаль орчны хяналтын улсын байцаагч Ш.Нархүү, Байгаль хамгаалагч М.Бат-Эрдэнэ нарт, хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудад хуваарьт талбайг хариуцуулан 7 хоног бүрийн баасан гарагт цэвэрлүүлж байхыг байгууллагын дарга, эрхлэгч, багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

4.Нийтийн их цэвэрлэгээтэй холбоотой төсвөөс гарах зардлыг Засаг даргын Тамгын газрын Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас тооцож олгохыг Тамгын газрын дарга (Р.Гантулга), нягтлан бодогч (Б.Дэлгэрдалай) нарт зөвшөөрсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.


ДАРГА  Б.ГАНТУЛГА



642201237

2023/Засаг дарга/Захирамж2023

Сумын Засаг даргын 2023 оны 03
дугаар сарын 20 -ний өдрийн 1129
тоот захирамжийн 01 дүгээр хавсралт



НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГАЗРЫН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ ХУВААРЬ

2023 оны 03 дугаар сарын 20

Пионер толгой

1. Айл өрхүүд хашааныхаа ар, өвөр, хажуу талын 50-100 метр радиус доторхи цэвэрлэгээг хийнэ.
2. Төрийн банк, Холбоо, Эрчим хүч - Зундуйжамцын урдаас Холбооны ар хүртэлх жалга
3. Хаан банк, Халуун ус – Холбооны араас халуун усны ар хүртэлх жалга
4. Эрүүл мэндийн төв, Усны харуул - Д.Эрдэнээгийнхээс усны харуулын байр хүртэл дэнж доогуурх болон голын захаар байгаа хог хаягдлыг
5. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар - Наадмын талбай, хүүхдийн парк
6. Цэцэрлэг, Соёл - Мал нядалгааны хашааны орчин
7. Сургууль - 50 жилийн ар
8. Цэнгэл 1 дүгээр баг Багруу гардаг замын дагуух талбай
9. Давааны ам 2 дугаар баг Багруу гардаг замын дагуух талбай
10. Буга 3 дугаар баг Багруу гардаг зам дагуух талбай
11. Хөвийн ам 4 дүгээр баг Багруу гардаг зам дагуух талбай
12. Пионер толгой 5 дугаар баг Хоёр суварганы хоорондох, хойд толгойн ар өвөр
13. Шатахуун түгээх станц- Байгууллагынхаа орчны цэвэрлэгээг 100 м радиуст хийх
14. Халиун тал ТББ байгууллагынхаа орчны цэвэрлэгээг хийх
15. Цаг уурч Цаг уурын орчны тайлбайн цэвэрлэгээг 100 метр радиуст хийх
16. Оёдлын цех орчны цэвэрлэгээг хийх
17. Уурын зуух орчны цэвэрлэгээг хийх
18. Гандан ойр орчмын цэвэрлэгээг хийх
19. Хогийн цэгийн наад хэсгийн том талбай дээр бүх байгууллагууд очиж туг хатгаж хуваарилсан талбайгаас авч цэвэрлэж, хогийг ачуулж, цэвэрлэсэн талбайгаа хүлээлгэж өгнө.

Сумын Засаг даргын 2023 оны 03
дугаар сарын 20-ны өдрийн 1129
тоот захирамжийн 12 дугаар хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГАЗРЫН ИХ ЦЭВЭРЛЭГЭЭНИЙ АЖИЛД
ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦОО

2023 оны 03 дугаар сарын 20

Пионер толгой

Д/д	Зардлууд	Хэмжих нэгж	Тоо/ хэмжээ	1бүрийн үнэ	Бүгд үнэ
1	2		3	4	5
1	Дизель түлш	литр	130	4140	538200
2	Масло/ мобиль/	литр	5	18000	90000
3	Тосол /антифриц/	литр	5	8000	40000
4	Ажлын бээлий	ширхэг	40	3000	120000
5	Маск	ширхэг	50	300	15000
6	Ажлын хувцас/ комбинзон/	ширхэг	2	80000	160000
	Дүн				963200

оОо